




Хөгжлийн үйлчилгээний төв  
Ажлын төв (Хөгжлийн үйлчилгээний төв)  
Төв, Улаанбаатар, Монгол Улс

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2020



# Мэндчилгээ

Эрхэм хүндэт нийтийн аж ахуйн салбарын нийт ажилтан, албан хаагчид, мэргэжил нэгт нөхөд, бидний үйл ажиллагааг үргэлж дэмжиж, хамтран ажилладаг байгууллагууд, хэрэглэгч та бүхэндээ Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааныхаа тайланг өргөн барьж байна.



Өнгөрсөн 2020 онд Зохицуулах зөвлөл нь хуулиар хүлээсэн чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд нийтийн аж ахуйн салбарын хууль эрх зүйн орчинг бэхжүүлэх, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний зохицуулалт, тусгай зөвшөөрлийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулан, нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн өртөг, зардлыг бууруулж, үр өгөөжийг дээшлүүлэх, хангагч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах, салбарын үйл ажиллагаа болон усны зөв зохистой хэрэглээний талаар олон нийтэд сурталчлан таниулах чиглэлээр ихээхэн үр дүнтэй ажиллаа.

Дэлхий нийгтийг хамарсан Ковид-19 цар тахал Монгол улсын нийгэм эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж байгаа нь салбарын байдалд ч хүндээр нөлөөлж байна. Гэсэн хэдий ч салбарын орлого өмнөх оноос 6.3% өсч 195.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. Зардал 16.8%-иар өссөнөөр салбарын хэмжээнд алдагдал 38.8 тэрбум төгрөгт хүрсэн. Ус хэрэглээ 5.6% өссөн нь айл өрхийн хэрэглээ нэмэгдсэнээс голчлон шалтгаалсан.

Салбарын санхүүгийн байдлыг дээшлүүлэх зорилгоор дунд ур хугацаанд хэрэгжүүлэх тарифын төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд эхний ээлжинд Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний зардал нөхөх төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж эхлээд байна.





Төрөөс хүн амын анхдагч хэрэгцээ болсон ус хангамжийн асуудалд онцгой анхаарч байгаа. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогодоо баталгаат ундны усаар хангагдсан хүн амын хувийг 2050 он гэхэд 90%-д хүргэх зорилтот түвшинг тодорхойллоо. Түүнчлэн 2019 оны Засгийн газрын 474 дүгээр тогтоолоор баталсан “Нийтийн аж ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай”, 2020 оны 94 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлого” зэрэгт энэ асуудлыг тодорхой тусгаж, сум, суурин газрын хүн амын ус, дулаан хангамжийн үйлчилгээг тухайн аймгийн нийтийн аж ахуйн байгууллагад хариуцуулан нэгдсэн удирдлага зохион байгуулалтанд оруулах зэрэг бодлогын түвшинд ач холбогдол бүхий арга хэмжээнүүдийг авч байна.

Монгол Улсын Засгийн газрын 474 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах, Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн, Хүн амын унд ахуйн усны чанарт тавих хяналтыг сайжруулж, ундны усны стандартын шаардлага хангасан усаар хүн амыг хангах ажлын хүрээнд олон ажлуудыг Зохицуулах зөвлөлөөс санаачлан ШУА-ийн Газарзүй-геоэкологийн хүрээлэн, Хими-химийн технологийн хүрээлэнгүүдтэй хамтран хэрэгжүүллээ. 2020 оны байдлаар Баянхонгор, Орхон, Дархан-Уул, Увс, Завхан, Говь-Алтай аймгууд болон Улаанбаатар хотын 9 дүүргийн ундны усны нийт 2577 гүний худгуудад усны чанарын судалгаа хийж, мэдээллийн сан байгууллаа.

Дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн 6-р зорилго болон Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” баримт бичгийг хэрэгжүүлэх ажлын дагуу Монгол Улсын иргэн бүрийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд ус хангамж, ариун цэврийн асуудлуудыг нь шийдвэрлэхээр шат дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.

2020 оны хувьд дэлхийн нийтийг хамарсан Ковид-19 цар тахал гарч, хүн бүрийн хувийн ариун цэвэр, сахилга бат, нийгмийн оролцоог шаардсан, улс орнуудын хамтын ажиллагаа, системтэй зохион байгуулалтад дүгнэлт гаргасан нэн хариуцлагатай жил болж өнгөрлөө. Нөгөө талаас цар тахалтай тэмцэж буй эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын шийдлүүд нь биднийг шинэ нөхцөлд дасан зохицох, амьдралын хэв маяг, дадал хандлагыг өөрчилж, өдөр тутмын үйл ажиллагаа, хурал, уулзалт, албан ажлуудыг цахим хэлбэрт шилжүүлэхэд ихээхэн түлхэц болж байна.

Цар тахлын үед иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн нөхцөл байдалд дэмжлэг үзүүлэхээр **Монгол Улсын Засгийн газраас 2020**

**оны 12-р сарын 13-ны өдрийн 211 тоот тогтоолоор айл өрхийн болон зарим үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын цэвэр, бохир усны төлбөрийг төрөөс хариуцах тухай** шийдвэр гаргасан. Тус шийдвэрийг хэрэгжүүлэх “Цэвэр, бохир усны хэрэглээг зохицуулах түр журам” болон “Төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөр тооцоог зохицуулах түр журам”-ыг 2020 оны 12-р сарын 18-ны өдөр Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар баталсан. Дээрх шийдвэрийн дагуу нийт 728.1 мянган айл өрх, 27.8 мянган аж ахуйн нэгж, байгууллагыг тус хөнгөлөлтөд хамрууллаа.

2021 оны хувьд иргэн бүр хариуцлагатай нийгмийг цогцлон бүтээхийн төлөө хүчин зүтгэсэн, салбарын байгууллагууд ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний үр шимийг дээшлүүлэн, найдвартай үйлчилгээ, шинэ боломж, сонголтуудыг бий болгож, ард иргэдийнхээ тав тухтай ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулан ажиллах сайхан жил болно гэдэгт итгэлтэй байна.

Мөн салбарт ажиллаж буй хүн бүр зөв хандлагатай, чин хүсэл эрмэлзэл, шударга үзэл баримтлалтай байж, иргэд олон нийтэд чанартай, соёлтой үйлчилгээг түгээн дэлгэрүүлэх, салбарын нэр хүндийг өндөрт өргөсөн, үнэтэй боловсон хүчин байж, салбарын байгууллагууд өөрсдийн нийгмийн хариуцлагаа ухамсарласан, бусдад үлгэр жишээ хамт олон байхын төлөө хичээнгүйлэн ажиллана гэдэгт эргэлзэхгүй байна.

Нийтийн аж ахуйн салбарын үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулан, Зохицуулах зөвлөлтэй хамтран ажилладаг та бүхэндээ байгууллагынхаа нэрийн өмнөөс талархы илэрхийлж, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ж.БАТСУУРЬ



**Алсын хараа:** Тогтвортой хөгжлийг хангах усны үйлчилгээг ухаалаг, уян хатан зохицуулагч манлайлах байгууллага байна.



**Эрхэм зорилго:** Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилтыг биелүүлэхүйц, Монгол хүний эрхийг хангасан баталгаатай, тэгш, хүртээмжтэй усны үйлчилгээг үр өгөөжтэй, тогтвортой, байгаль орчинд ээлтэй хөгжүүлэх оновчтой зохицуулалтыг хийхэд оршино.

1

### СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Усны үйлчилгээг хэрэглэгчид шударгаар, тэгш хүртэх боломжийг хангах;

2

### СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Усны үйлчилгээний давамгайл байдлалд үр дүнг чухалчилсан зохицуулалт хийх;

3

### СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Хангагч байгууллагын хариуцлагыг дээшлүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх;

4

### СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн зохицуулалтыг хэрэгжүүлэх;

5

### СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Мэдлэг чадварт суурилсан мэргэшсэн манлайлагч байгууллага болох



## ОРШИЛ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт зааснаар Зохицуулах Зөвлөл нь тухайн нутаг дэвсгэрт усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуурга /цаашид “УХАТ” гэх/-ын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй бөгөөд хуулийн 10 дугаар зүйлд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Зохицуулах Зөвлөл Монгол Улсад УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг үр ашигтай явуулах нөхцөл бололцоог бүрдүүлэн, дэлхийн жишигт нийцсэн чанар стандарт бүхий найдвартай, тэгш, хүртээмжтэй үйлчилгээг хот, суурины хэрэглэгчдэд хүргэх, баталгаажуулах оновчтой зохицуулалтыг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.





## НЭГ. ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

### ҮНЭ, ТАРИФЫН ЧИГЛЭЛЭЭР

1.1. Хуулийн 10.1.1 дэх заалт буюу цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр тогтоох аргачлал, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчилгээний тарифыг хянаж батлах, нийтлэх ажлын хүрээнд:

Улаанбаатар хотын “УСУГ” ОНӨААТҮГ, Төв аймгийн “Төв Чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ, Хөвсгөл аймгийн “Хөвсгөл ус суваг” ХХК, Орхон аймгийн “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК, Дархан-Уул аймгийн “Дархан ус суваг” ХК, Өвөрхангай аймгийн “Онги ус суваг” ОНӨААТҮГ, Говьсүмбэр аймгийн “Ус-Ду” ОНӨААТҮГ, “Талын Илч” ОНӨААТҮГ, Архангай аймгийн “Ар ус ундарга” ХХК, Баян-Өлгий аймгийн “СУАТ” ХХК, Завхан аймгийн “Амь ус трейд” ОНӨААТҮГ, Өмнөговь аймгийн “Гүний ус” ХХК, Сүхбаатар аймгийн “Дөрвөлж” ХХК, Сэлэнгэ аймгийн “Урсгал ус” ХХК-уудын хэрэглэгчийн тариф, Завхан аймгийн Асгат, Дөрвөлжин, Идэр, Отгон, Цагаанчулуут, Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Жаргалант, Дорнод аймгийн Матад сумуудын гэр хорооллын усны үйлчилгээний тариф, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум, Цагааннуур сум, Ерөө сумын Бугант тосгоны



хэрэглэгчийн тарифт зохицуулалт хийж, холбогдох материалыг бүрдүүлэн Захиргааны ерөнхий хуулийн 64.1-д заасны дагуу нөлөөллийн шинжилгээг боловсруулан захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. 2020 онд доорх 10 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ирүүлсэн бөөний тарифын саналыг хянаж борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг шинэчлэн баталсан. Үүнд:

- “Баганат өргөө” ХХК;
- “Ди Ди Прогресс” ХХК;
- “Тэлмүүн орд” ХХК;
- “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК-ийн “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-н Ус хангамжийн цехтэй хийх бөөний тариф;
- “Голдкомпас ХХК”;
- “Жинст өргөө” ХХК;
- “Эмпати Хаус” ХХК;
- “Дунд мандал” ХХК;
- “Юлтүйнатурал” ХХК;
- “Баярс констракшн” ХХК.
- “Чандмань Хүрд” ХХК-ийн “ОСНААУГ” ОНӨААТҮГ-тай тооцоо хийх дамжин тарифыг батлав.

Захиргааны ерөнхий хуулийн дагуу эрх зүйн хэм хэмжээний 19 актыг хэрэглэгчийн нөлөөллийн шинжилгээ, тайлбар, судалгааны хамт материал бүрдүүлж, файлын сан үүсгэн Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэв.

Цэвэр, бохир усны төлбөр тогтоох аргачлалд бороо, хөрсний усанд төлбөр тооцох болон цэвэр усны хорогдол, бохир усны шингээлтийн асуудлыг нэмэлтээр оруулав.







1.2 Хуулийн 10.1.2 дахь заалт буюу үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийн хэмжээг тогтоох ажлын хүрээнд:

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, тарифт тусгасан хэмжээ, хөрөнгө оруулалтын тайланг 2019 оны гүйцэтгэлээр нэгтгэв.



Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үндсэн хөрөнгийн элэгдэл, түүний зарцуулалтад хяналт тавьж, элэгдлийн зарцуулалтыг хянах журам боловсруулахад зориулж Англи улсын OFWAT байгууллагын туршлагыг судалсан.

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**

1.3. Хуулийн 10.1.3 дахь заалт буюу Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох ажлын хүрээнд:

Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүсэлтүүдийг тухай бүр хүлээн авч санхүү, эдийн засгийн байдалд үнэлгээ хийн, зардалд хяналт тавьж, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага хангасан 58 аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг шинээр олгох, сунгах, хүчингүй болгох асуудлыг Зохицуулах зөвлөлийн хуралдаанд оруулан хэлэлцүүлж, шийдвэрлэв.



Тайлант хугацаанд 24 аж ахуйн нэгж, байгууллагад ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгож, 31 аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгаж, 3 аж

ахуйн нэгж байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг судлан шийдвэрлэв. Тусгай зөвшөөрөл шинээр авсан, сунгуулсан 58 аж ахуйн нэгж, байгууллагатай гүйцэтгэлийн гэрээг байгуулав.

Тусгай зөвшөөрөл олгосон байдлыг хүснэгтээр харуулбал:

**ХҮСНЭГТ 1**

№	Тусгай зөвшөөрлийн нэр, төрөл	Шинээр олгосон	Сунгасан	Хүчингүй болгосон
1.	Орон сууцны доторх цэвэр, бохир усны шугам, сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр	4	15	2
2.	Аймаг, орон нутгийн ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр		9	
3.	Бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээний чиглэлээр	16	17	1
4.	Цэвэрлэх байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээ болон УХАТ-ын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээ	2		
5.	Цэвэрлэх байгууламжийг шинээр барьж, байгуулах	2		
6.	Ус олборлон, цэвэршүүлэх байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээ			
Нийт		24	31	3

Хүснэгт 1-ээс харахад шинээр тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллагын 17%-ийг Улаанбаатар хотод орон сууцны доторх цэвэр, бохир усны шугам, сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр, 67%-ийг бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээний чиглэлээр, 8%-ийг УХАТ-ын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээ эрхлэх чиглэлээр, 8%-ийг цэвэрлэх байгууламжийг шинээр барьж, байгуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага эзэлж байна. Үүнийг графикаар харуулбал:

График 1. Тусгай зөвшөөрөл шинээр авсан байдал /%/



2020 оны байдлаар улсын хэмжээнд ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг харуулбал:

**ХҮСНЭГТ 2**

№	ТЗЭ-ийн үйл ажиллагааны төрөл	тоо
1.	Орон нутгийн НАА-н байгууллагууд	47
2.	Улаанбаатар хотын орон сууц ОНӨААТҮГ-ууд	3
3.	Улаанбаатар хотын хувийн хэвшлийн-ТЗЭ	79
4.	УХАТ-ын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээ	4
5.	Цэвэр ус цэвэршүүлэн савлах үйлдвэр-ТЗЭ	2
6.	Бохир усыг тусгай зориулалтын машинаар соруулах үйлчилгээтэй ТЗЭ	62
7.	Цэвэрлэх байгууламж шинээр барих болон туршилт тохируулга	5
8.	Цэвэрлэх байгууламжийн ашиглалт, үйлчилгээ болон туршилт тохируулга	3
<b>Нийт</b>		<b>205</b>

1.4. Хуулийн 10.1.4 заалт буюу Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах:

Тусгай зөвшөөрлийн хугацаа 2020 онд дуусаж буй нийт 51 аж ахуйн нэгжид, 2021 оны 1 дүгээр улиралд дуусах 19 аж ахуйн нэгжид тус тус тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах албан бичгийг хүргүүлсэн.

1.4.1 Дараах 22 аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, чадамж, тарифын хэрэгжилтийг газар дээр нь шалгаж, зөвлөгөө өгч, тайлан, дүгнэлт гаргаж ажиллалаа. Үүнд:

- “Тэшиг-ус” ОНӨААТҮГ;
- “Хит Повер Теч” ХХК;
- “Тэргэл Мөнх” ХХК;
- “Сод эгшиг” ХХК;
- “Баян газрын хишиг” ХХК;
- “Баганат харш” ХХК;
- “Юлтүйнатурал” ХХК;
- Хэнтий аймгийн “Бор-Өндөр хот тохижилт” ОНТҮГ;
- “Смарт План” ХХК;
- “Баянмонгол хотхон” ХХК;
- “Баянгазрын хишиг” ХХК;
- “Төгс Инженеринг-ЦБ” ХХК;
- “Хайспид” ХХК;
- “Дэнж хотхон” ХХК;
- “Тунамал арвижих өргөө” ХХК;
- Баатар Дулаан Хан ХХК;
- Эмпати Хаус ХХК;
- Тэлмүүн Орд ХХК;
- Хүннү Хотхон ХХК;
- Трю Эл Менежмент ХХК;
- Түмэн Наяд Хайрхан ХХК;
- “Тунгалаг Буянт Дуут” ХХК.



1.4.2. Орон нутгийн 49, Улаанбаатар хотын 81, нийт 140 аж ахуйн нэгж, байгууллагад 2020 оны тайлан мэдээг ирүүлэх тухай албан бичиг хүргүүлэв.

1.4.3. Улаанбаатар хотын орон сууцны доторх цэвэр, бохир усны шугам, сүлжээний ашиглалт, засвар,

үйлчилгээний чиглэлээр шинээр авсан 4, сунгуулсан 10, нийт 14 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг нөхцөл, шаардлагын хүрээнд газар дээр нь шалгаж, үүрэг даалгавар өгч ажиллав.

1.4.4 Тусгай зөвшөөрлийн төрөл нэмүүлэхээр хүсэлт ирүүлсэн ИНЕГ-ийн харъяа “Нисэх буудлуудын удирдах газар”-ын үйл ажиллагаа нь ус хангамж, ариутгах татуургын нөхцөл, шаардлага хангаж буй эсэхийг газар дээр нь шалгаж, үнэлгээ өгөв.





1.4.5 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон байр бүртгэлтэй холбоотой асуудлаар гарсан маргааныг сонсох ажиллагаа зохион байгуулж, шийдвэрлэв. Тухайлбал, "УСУГ" ОНӨААТҮГ, "ОСНААУГ" ОНӨААТҮГ болон "Эй Ди Констаркшн" ХХК зэрэг байгууллагуудыг байлцуулан байр бүртгэлийн асуудлаар сонсох ажиллагааг зохион байгуулан, үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийг хангуулав.




1.4.6 Мөн "Зүмбэр орд өргөө" ХХК болон "УСУГ" ОНӨААТҮГ, "Гантус Өргөө" ХХК болон "УСУГ" ОНӨААТҮГ, "Аж богд инженеринг болон "Шинэ яармаг хан богд" ХХК, "Баатар дулаан хан" ХХК болон "ОСНААУГ" ОНӨААТҮГ-ын ХҮТ-1, "Комфорт Монгол нэтворк" ХХК, "Х апартамент" СӨХ, "Баатардулаан хан" ХХК, "Алтаргана хотхон" СӨХ, "Эрчим скай стар" ХХК зэрэг аж ахуйн нэгж байгууллага, СӨХ-дын төлөөллийг байлцуулан үүссэн маргаантай асуудлаар сонсох ажиллагааг тус тус зохион байгуулан, асуудлыг шийдвэрлэв.



1.5 Хуулийн 10.1.5 заалт буюу Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх ажлын хүрээнд:

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой иргэн, хуулийн этгээдээс бичгээр болон утсаар ирүүлсэн 140 орчим өргөдөл, гомдол, асуудал шийдвэрлүүлэх хүсэлтийг судалж, барагдуулав.



Хангагч, хэрэглэгчийн хооронд үүссэн үнэ тарифтай холбоотой 17, тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд үүссэн үнэ тарифтай холбоотой 10 маргаантай асуудлыг шийдвэрлэв.

1.6 Тусгай зөвшөөрлийн журам, аргачлал, зааврыг боловсронгуй болгох, хууль, дүрэмд санал өгөх чиглэлээр:

1.6.1 "Икон Консалтинг" ХХК-иас ирүүлсэн "Барилга доторхи ус хангамж, ариутгах татуурга" барилгын норм ба дүрэм БНБД 40-05-16-д Зохицуулах зөвлөлийн 2020 оны 02/1047 тоотойр Усны хэрэглээний нормыг шинэчлэх асуудлаар санал өгсөн.

1.6.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагаас 2019 оны тайлан мэдээ авах маягтыг шинэчлэн, байгууллагын сайтад байршуулан, мэдээлснээр ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний мэдээлийн сангийн өгөгдлийг бүрдүүлэн ажиллав.

1.6.3 БХБЯ-аас боловсруулсан Орон сууц, НАА-н талаар Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх төлөвлөгөөнд холбогдох саналуудыг тусгуулж ажиллав.

1.6.4 Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын шинээр байгуулж буй мэдээллийн санд санал боловсруулж 01/151 тоотойр хүргүүлэв.







- 1.6.5 Усхангамж, ариунцэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь сэдэвт уулзалтаас гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2020 оны төлөвлөгөөний дагуу зорилтыг хэрэгжүүлэх ажлыг боловсруулан хүргүүлэв.
- 1.6.6 "Сумын хөгжил" төсөл боловсруулах ажлын хэсгийн хуралд дулаан хангамжийн үйл ажиллагааг давхар хариуцдаг сумдын өнөөгийн байдлын талаар товч танилцуулгыг бэлдэж, санал өгч оролцов.
- 1.6.7 БХБЯ дээр 5582:2006 стандартыг хүчингүй болгосонтой холбоотой үүссэн асуудлын талаар хэлэлцүүлэгт оролцон, санал өгөв.
- 1.6.8 Ноос, ноолуурын холбооноос ХХААХҮЯ, БХБЯ-д албан бичиг өгсний дагуу БХБЯ болон тус холбооны төлөөлөгчтэй хамтран тус үйлдвэрүүдээр явж, газар дээр нь танилцсан. Мөн Нийслэлийн Захирагчийн ажлын албан дээрх ажлын хэсгийн хуралд оролцож, стандартын шаардлага хангасан бохир ус нийлүүлж буй үйлдвэрүүдийг ажиллуулах нэгдсэн нэг ажлын хэсэг гаргах санал өгөв.
- 1.6.9 Төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний талаарх хууль, эрх зүйн орчны байдал, тэдгээрт хийх зохицуулалтын талаар "WASH Action of Mongolia" төслийнхөтэй онлайнаар холбогдон, санал өгөв.



## ХОЁР. ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХЭД ХАМААРАХ АСУУДЛААР ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРАМ, ЗААВРЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

- 2.1 Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбоотой саналыг УИХ-ын Байгаль орчин, хүнс, ХАА-нбайнгын хорооны дарга болон Барилга, хот байгуулалтын сайдад 01/40 тоотой хүргүүлэв.
- 2.2 Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбоотой саналыг Барилга, хот байгуулалтын яаманд 01/41 тоотой хүргүүлэв.
- 2.3 Хот, суурины ус хангамж, ариутгах татуургыг шинээр барьж байгуулах, шинэчлэх болон түүний ашиглалт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагад зарим нэмэлт, өөрчлөлт оруулан, Захиргааны хэм хэмжээний актын бүртгэлд бүртгүүлсэн.
- 2.4 Барилга байгууламж шинээр бүртгэх журмыг 2020.02.20-ны А/08 тоот тушаалаар шинэчлэн батлав.
- 2.5 Зохицуулах зөвлөлийн Томилолтын журмыг төслийг шинэчлэн боловсруулж, Зохицуулах зөвлөлийн даргын 2020 оны А/16 тоот тушаалаар батлав.
- 2.6 Барилга, хот байгуулалтын яамнаас ирүүлсэн Барилга угсралтын ажлын тусгай зөвшөөрлийн журамд санал боловсруулж, хүргүүлсэн.
- 2.7 Аж ахуйн харилцааны дүрэмд нэмэлт оруулж, ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 3744 дугаарт бүртгүүлэв.
- 2.8 Улаанбаатар хотын "УСУГ" ОНӨААТҮГ-аас бороо, хөрсний усанд төлбөр тогтоолгох хүсэлт ирүүлсний дагуу холбогдох судалгааг хийж, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр тогтоох аргачлалд нэмэлт, өөрчлөлт оруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.
- 2.9 Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын хүрээнд БХБЯ-наас батлан гаргах "Цэвэр, бохир усны хэрэглээг зохицуулах түр







журам” болон “Төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөр тооцоог зохицуулах түр журам”-ын төслийг боловсруулж, батлуулсан.

- 2.10 Зохицуулах зөвлөлийн 2020 оны хуралдаанаас нийт 110 тогтоол батлагдсан бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн дагуу Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх 17 тогтоолыг холбогдох материалын хамт ХЗДХЯ-нд хүргүүлж захиргааны хэм хэмжээний актын бүртгэлд бүртгүүлэв.
- 2.11 ШУА-тай хамтран ажиллах санамж бичгийн дагуу Хими, химийн технологийн болон Газарзүй геоэкологийн хүрээлэнтэй хамтран Ундны усны чанарын судалгааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:
- Говь-Алтай, Завхан, Увс аймаг, Нийслэлийн 8 дүүргүүдэд ундны усны чанарын суурь судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгэв.
  - Говь-Алтай, Завхан, Увс аймаг, Нийслэлийн 8 дүүргүүдэд хэрэгжүүлсэн Ундны усны чанарын суурь судалгааны ажлын дүгнэлт, зөвлөмжийн номыг хэвлүүлэн, худаг ашиглалтын дэвтрийн холбогдох мэдээллийг бэлтгэн тус аймаг, дүүргүүдийн Засаг Даргын Тамгын газарт хүлээлгэн өгөв.
  - Нийслэлийн Байгаль орчны газар болон Улаанбаатар хотын ундны усны чанарын суурь судалгааны ажлын тайлан, зөвлөмжийг хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд холбогдох танилцуулгыг хийж, уулзалт зохион байгуулав.



## ГУРАВ. ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ӨДӨР ТУТМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

- 3.1 Зөвлөлийн даргын нийт 62 тушаал /үйл ажиллагаатай холбоотой 42, боловсон хүчний 20/-ыг баталж, хэрэгжилтийг хангуулав.
- 3.2 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай нийт 31 гэрээ байгуулан ажиллав. Мөн Барилга, хот байгуулалтын Сайдтай Хамтран ажиллах санамж бичгийг 3 жилийн хугацаатай байгуулав.
- 3.3 Зохицуулах зөвлөл нь 2020 оны жилийн эцсийн байдлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 1263 албан бичиг хүлээн авч бүртгэл хөтлөн, хариуцсан мэргэжилтэнүүд нь судлан шийдвэрлэн, ажиллаж байна. Үүнээс хаагдсан 1254, шийдвэрлэх шатандаа 9 /гүйцэтгэл 99.3%/ албан бичиг байна. Мөн нийтдээ 788 албан бичгийг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад явуулав.
- 3.4 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 66 өргөдөл, гомдол /иргэд, хуулийн этгээдээс 55, боловсон хүчинтэй холбоотой 11/ ирснээс 66 өргөдөл, гомдолд хариу өгч, шийдвэрлэсэн /биелэлт 100%/ байна.
- 3.5 Байгууллагын дотоод мэдээлэлийн програмд нийт ирсэн албан бичиг 1263, явуулсан албан бичиг 788, өргөдөл гомдлын 66 бичгийг оруулж, цахим архивын санг баяжуулав.
- 3.6 Зохицуулах зөвлөлийн даргын итгэмжлэлээр хууль сахиулах байгууллагад байгууллагыг төлөөлөх, хэрэг хянан шийдвэрлэхэд шаардлагатай нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөх, маргаан шийдвэрлэх ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг явуулав. Үүнд:
- 3.6.1 Нийслэл дэх ЗХАШ-ны шүүхэд хянагдаж байгаа “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын нэхэмжлэлтэй, тус Зөвлөлд холбогдох захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралд оролцсон бөгөөд шүүхээс маргаан бүхий шийдвэрийн үйлчлэлийг түдгэлзүүлж, 4 сарын дотор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын саналыг харгалзан шийдвэрлэхээр болсны дагуу Зохицуулах зөвлөлийн 2020 оны 36 тоот тогтоолыг гаргасныг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас эс зөвшөөрч дээр дурдсан шүүхэд дахин








нэхэмжлэл гарган захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариу тайлбар, хүсэлтийг гаргав.

- 3.6.2 ХУД-ийн ИХАШ-ны шүүхийн 2020.02.13-ны 828 тоотын дагуу “Баатардулаан хан” ХХК-ийн нэхэмжлэлтэй, “Монь ивээл” ХХК-нд холбогдох иргэний хэрэгт тус Зохицуулах зөвлөл шинжээчээр оролцохоор томилогдсонтой холбогдуулан шинжээчээр ҮТА-ны Ахлах мэргэжилтэн С.Нямдавааг томилсон бөгөөд тэрээр шүүхэд шинжээчийн дүгнэлтийг гаргав.
- 3.6.3 Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020.03.30-ны өдрийн 1/2717 тоотын дагуу “Адмон принт” ХХК-ийн нэхэмжлэлтэй “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-т холбогдох захиргааны хэрэгт Зохицуулах зөвлөлийг шинжээчээр томилсонтой холбогдуулан байгууллагыг төлөөлж шинжээчээр Тусгай зөвшөөрлийн албаны мэргэжилтэн Ш.Энхжаргалыг томилсон бөгөөд тэрээр шүүхэд шинжээчийн дүгнэлтийг гаргав.
- 3.6.4 Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж байгаа “Дэнж хотхон” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт хариу тайлбар гаргах, урьдчилсан хэлэлцүүлэгт оролцох, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг гардаж авав.
- 3.6.5 Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхэд хянагдаж байгаа “Зүмбэр орд өргөө” ХХК-ийн нэхэмжлэлтэй тус Зохицуулах зөвлөлд холбогдох захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцсон бөгөөд шүүхээс Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхий шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгч талын давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлэв.
- 3.6.6 БЗД-ийн ИХАШ-ны шүүхийн 2020.01.08-ны 215 тоот шаардлагын дагуу холбогдох нотлох баримт, албан тоотын төслийг бэлтгэж, 2020.01.09-ний 01/24 тоотоор илгээв.

- 3.6.7 БГД-ийн ИХАШ-ны шүүхийн 2020.01.21-ний 1/359 тоотын дагуу холбогдох нотлох баримтыг бэлтгэж, Зохицуулах зөвлөлийн 2020.01.29-ний 01/68 тоотоор илгээв.
  - 3.6.8 СБД-ийн Цагдаагийн 2-р хэлтэст хянагдаж байгаа Э.Пүрэвжавд холбогдох эрүүгийн хэргийн материалтай танилцаж, шаардлагатай нотлох баримтыг бэлтгэж, 2020.01.07-ны 01/16 тоотоор хүргүүлэв.
  - 3.6.9 ХУД-ийн ИХАШ-ны шүүхийн 2020.05.07-ны 1/01953, 2020.06.03-ны өдрийн 183/АБ2020/02312 тоот нотлох баримт хүссэн албан тоотын дагуу холбогдох нотлох баримтыг тус тус гаргаж өгөв.
  - 3.6.10 СБД-ийн ИХАШ-ны шүүхэд “Хүрээ хаус” ХХК-ийн цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөрийг үнэ зөв нэхэмжилсэн эсэх асуудлаар холбогдох нотлох баримт, албан тоотыг бэлтгэж, 2020.09.28-ны 01/620 тоотоор илгээв.
- 3.7 Тус Зохицуулах зөвлөлөөс Ковид-19 цар тахлын үед хэрэглэгчдэд ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг тасралтгүй, найдвартай хангах үүргийг хүлээн Засгийн газрын 2020 оны 178,211 дугаар тогтоолын дагуу хуваарь гарган ажиллаж байгаатай холбогдуулан албаны болон албан ажлын шаардлагаар ажиллах шаардлагатай зарим албан хаагчдын автомашинуудад тээврийн хэрэгслийн зорчих тусгай зөвшөөрөл бүхий QR кодыг Нийслэлийн онцгой байдлын газраас авав.







## ДӨРӨВ. ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭР, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

- 4.1 Зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга, Тусгай зөвшөөрлийн албаны дарга Г.Нарантуяа 2020 оны 3 дугаар сарын 25-нд TV-2 , 2020 оны 3 дугаар сарын 26-нд NTV телевизүүдэд Дэлхийн усны өдрийн талаар болон ус хангамж ариутгах татуургын өнөөгийн байдал, хууль эрх зүйн орчин, Засгийн газрын 2020 оны 474 дүгээр тогтоолын талаар мэдээлэл өгөв.
- 4.2 МҮОНРТ-ийн Монголын мэдээ сувгийн 2 сарын 02-ны өдрийн Парламентын хэлэлцүүлэгт орон сууцнуудыг СӨХ хариуцдаг байдлыг өөрчилж мэргэжлийн байгууллагуудад шилжүүлэх шаардлага, боломж, гарц шийдэл сэдвийн хүрээнд оролцов.



- 4.3 Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын хүрээнд тус Зохицуулах зөвлөлөөс боловсруулан БХБЯ-наас батлан гаргасан “Түр журам батлах тухай” 242 тоот тушаалын талаарх мэдээллийг онлайнаар Улаанбаатар хотын болон аймаг, орон нутгийн ТЗЭ-дэд хүргэх ажлыг 3 удаа, төлбөрийн мэдээллийг хүргэх ажлын талаар БХБЯ-аас зохион байгуулсан онлайн хурлыг 2 удаа тус тус зохион байгуулсан.
- 4.4 Нийтийн аж ахуйн 89 жилийн ойн мэндчилгээ болон “Хэрэглэгчээ сонсоё” нээлттэй өдөрлөгийн мэдээллийг X/8,9,12,13-ний өдрийн “Өнөөдөр”, “Өдрийн сонин”-д тус тус нийтлүүлсэн.



- 4.5 Зохицуулах зөвлөлийн дарга Ж.Батсуурь IV/7-ны өдөр Эко, ТМ телевизүүдэд ийн Эрүүл Монгол хөтөлбөрт “Усны чанар, түүнтэй холбоотой хэрэгжүүлж буй арга хэмжээ”, “Нүхэн жорлон ба түүнээс гарах сөрөг үр дагаврууд”, “00-ын хувьсгал” зэрэг сэдвээр ярилцлага өгөв.
- 4.6 Салбарын мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх үйл ажиллагааг сайжруулах зорилгоор “Дундговь ус” ОНӨҮГ-ыг цахим хуудастай болгов. <https://dundgovi.water-mongolia.com/mn/>
- 4.7 Үнэ тарифын албаны дарга Ж.Гэрэлчулуун V/15-нд OTV –ийн Мэдээний цагт, X/9-д MNB, Мэдээний цагт усны үйлчилгээний үнэ тарифын талаар ярилцлага өгөв.





4.8 Зохицуулах зөвлөлийн дарга Ж.Батсуурь “Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний хэрэглэгчдээ сонсьё” өдөрлөгийн талаар IX/29-нд Монголын мэдээний Зочны цаг, X/8,9-нд Монголын Үндэсний Радио, МҮОНРТ, Ийгл, Парламентын телевиз, ECO, ТВ24, ТВ9, 25-р суваг, NTV, Live телевизүүд, Tur.mn Gogo.mn, Zarig.mn, Ergelt.mn, Shuud.mn, newswire.mn, asu.mn цахим сүлжээ, МОНЦАМЭ мэдээллийн сувгаар тус тус ярилцлага өгсөн.




4.9 БХБЯ, НҮБ-ын Хүүхдийн Сан, КОЙКА-тай хамтран зохион байгуулсан “КОВИД-19 цар тахлын үед ус хангамж, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний тогтвортой менежментийг хангах нь” сэдэвт зөвлөлдөх уулзалтын мэдээллийг МҮОНРТ, Mongol HD, UBS, Star, ТВ24, ТВ9,

25-р суваг, SBN, Live телевиз, Gogo.mn, Tur.mn, Ergelt.mn, Shuud.mn, newswire.mn, Монголын Үндэсний Радио, zaluu.com, dorgio.mn, yazguur.mn, [newspress.mn](http://newspress.mn), [newsmongolia.mn](http://newsmongolia.mn) цахим сүлжээ, Үндэсний шуудан, Өдрийн сонин, Өнөөдөр сонин МОНЦАМЭ зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр.

4.10 Зөвлөлийн дарга Ж.Батсуурь XI/5-нд “Улаанбаатар хотын усны хэрэглээ болон гүний худгийн талаар”, албаны дарга Г.Нарантуяа XI/5-нд “Саарал усны талаар” МНВ, Мэдээний цагт тус тус ярилцлага өгөв.

4.11 Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 474 дүгээр тогтоолын 2-р зүйлд заасан Усны чанар, аюулгүй байдлын талаар мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд байгууллагын [www.wsrc.mn](http://www.wsrc.mn) домайн нэр дээр тус мэдээллийн сан үүсгэн ажиллав.

4.12 Ариун цэврийн байгууламжийн талаар иргэд олон нийтэд зориулан “Бохир ус гэж юу вэ, түүнийг хэрхэн цэвэрлэдэг вэ?”, “Ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний тогтвортой менежмент яагаад хэрэгтэй вэ?”, “00-ын хувьсал”, “Ил задгай бие засах болон нүхэн жорлонгоос үүсэх сөрөг үр дагаврууд” богино хэмжээний анимейшныг “Лайфлинк” ХХК-тай хамтран хийв.



4.13 Дэлхийн 00-ын өдрийг тохиолдуулан XI/19-ний өдөр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын COVID19-с өөрийгөө болон бусдыг хамгаалах 5 арга хэмжээний тухай видеог байгууллагын фейсбүүк хуудсанд байршуулав.

4.14 ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнгээс 2020.11.19-





ний өдөр гаргасан “Халдварын эрсдэлтэй бүсэд ажиллаж байгаа ажилтан, алба хаагчдын хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зөвлөмж”-ийг байгууллагын фейсбүүк хуудсанд байршуулсан.

## ТАВ. ГАДААД БОЛОН ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- 5.1 2020 онд аймгуудын Засаг дарга нартай байгуулах гэрээнд оруулах саналыг боловсруулан Барилга хот байгуулалтын сайдад 01/51 тоотор хүргүүлэв.
- 5.2 БХБЯ-ны “ОСНАА-н ХАБЭА-н салбар хороо”-ны ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, ХАБЭА-н талаар хийх ажлын төлөвлөгөөнд санал оруулав.



- 5.3 “Лагийг дахин ашиглахад тавигдах ерөнхий шаардлага” стандартын төсөлд Зохицуулах зөвлөлийн саналыг боловсруулж БХБЯ-ны НАА-н бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 01/168 тоотор хүргүүлэв.



- 5.4 “УСУГ” ОНӨААТҮГ-ын хариуцдаг цэвэрлэх байгууламж болон бохирдуулагч үйлдвэрүүдийг стандартын дагуу бага оврын цэвэрлэх байгууламжтай болгох саналыг боловсруулж Нийслэлийн Захирагчийн ажлын албанд өгөв.

- 5.5 АХБ-наас зохион байгуулсан ТТ-9100 төслөөр хэрэгжиж буй “Бохир усны лагийг ашиглахад тавигдах ерөнхий шаардлага” стандарт, “Ариун цэврийн байгууламжаас гарах өтгөн лагийг суллах, тээвэрлэх, боловсруулахад тавигдах ерөнхий шаардлага” стандартуудын төслийн хэлэлцүүлэгт оролцож санал хүргүүлэв.



- 5.6 Азийн усны хорооны Удирдах зөвлөлийн 11-р хуралд онлайнаар оролцов.



- 5.7 Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төв, Зохицуулах зөвлөлөөс хамтран Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын удирдах ажилтнуудын уулзалт, семинарыг 2020.08.08-ны өдөр Төв аймгийн Зуунмод суманд зохион байгуулав.

- 5.8 Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.1.12, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/412 дугаар тушаалаар баталсан “Орчны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр /2017-2020 он/-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.2.1 дэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор ЭМЯ, УСУГ-тай хамтран 7 дугаар сард Хэнтий аймгийн ус хангагч байгууллагад усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтэд хөндлөнгийн аудитыг газар дээр нь хийж мэргэжлийн арга зүйгээр хангаж, ажилласан.





5.9 Улаанбаатар хотын “УСУГ” ОНӨААТҮГ-ийн зардал нөхөх төлөвлөгөөг боловсруулж, Нийслэлийн Засаг даргатай хамтран батлав.



5.11 Монгол Улсад Нийтийн аж ахуйн салбар үүсч хөгжсөний 89 жилийн ойг тохиолдуулан Нийслэлийн Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын дунд “Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилтны өдөр-2020” өдөрлөгийг зохион байгуулсан.

5.12 Бохир усыг хэмжих хэрэгслийн хэрэглээг нэвтрүүлэх, түүний ашиглалтыг сайжруулахад хамтран ажиллах саналыг 2020.04.16-ны өдрийн 01/226 тоотойр Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлсэн.



5.10 Монгол Улсад Барилгын салбар үүсч хөгжсөний 94 жилийн ойг тохиолдуулан 2020.09.04-ний өдөр Барилгачдын талбайд зохион байгуулсан нээлттэй өдөрлөгт оролцов.



5.13 Нийслэлийн Засаг даргын 2020.5.15-ны өдрийн А/661 дугаар захирамжийн дагуу Засгийн газрын 73 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хэсгийн хэлэлцүүлэгт тухай бүр оролцож, санал өгч ажиллав. Мөн ажлын хүрээнд бохирдуулагч үйлдвэрүүдийн судалгааг үндэслэн, Сонгинохайрхан дүүргийн мах, сүү, ундаа, жүүсний үйлдвэрүүд, машин угаалгын газрууд зэрэг нийт 70 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг газар дээр нь шалгаж, зөвлөгөө, мэдээллээр ханган ажиллав.







- 5.14 Ус цаг уурын орчны шинжилгээний газраас сүүлийн 10 жилийн хур тунадсын хэмжээ, мөн “УСУГ” ОНӨААТҮГ-ын Төв цэвэрлэх байгууламжид нийлүүлэгдсэн бохир усны талаар нэгдсэн судалгааг хийв. “УСУГ” ОНӨААТҮГ-ын хариуцдаг цэвэрлэх байгууламжийн талаар болон үйлдвэрүүдийн цэвэрлэх байгууламжийг стандартын дагуу бага оврын цэвэрлэх байгууламжтай болгож ажиллуулах саналыг НЗАА-ны ажлын хэсэг болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид 2020 оны 01/1048 тоотор хүргүүлсэн.
- 5.15 Аймгуудын Мэргэжлийн хяналтын газар болон Байгаль орчны газруудад Засгийн газрын 2020 оны 474 дүгээр “НААҮ-ний талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах албан бичгийг 2020.01.24-ний 01/60 тоотор хүргүүлсэн. Мөн тогтоолын хэрэгжилтийн талаар холбогдох судалгааг хийв.
- 5.16 УИХ-ын 2019 оны 62 дугаар тогтоолын хэрэгжилтийн биелэлтийг БХБЯ-нд 01/117 тоотор хүргүүлэв.
- 5.17 Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт орсны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран ажиллаж Зохицуулах зөвлөл ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын улсын 4 байцаагчтай болсон. Мөн Улсын Ерөнхий прокурорын газраас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны харъяаллыг тогтоолгов.
- 5.18 Зохицуулах зөвлөл нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.15-д заасны дагуу ус хангамж, ариутгах татуурын улсын байцаагч 4, санхүүгийн улсын байцаагч 2, улсын ахлах байцаагч 1-тэй болов.



5.19 Азийн Усны холбооны гишүүнчлэлийн хугацааг 3 жилээр сунгуулсан.



5.20 “Жорлонгоо өөрчилъе” төслийг санаачлагч Нутгийн шийдэл ТББ-ын Тэргүүн Ц.Оюунгэрэл, Б.Дашням нартай уулзал зохиож, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн шийдлийн хүрээнд, тус төслөөс хэрэгжүүлж буй ажлуудтай танилцав.



5.21 Стандарт хэмжил зүйн газар, ШУА-тай байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд 2020 онд хийх ажлын төлөвлөгөөг тус тус боловсруулан, батлуулав.





5.22 Монгол Улсын Засгийн газар болон Мянганы сорилтын корпорацийн хооронд байгуулсан “Мянганы сорилтын компакт гэрээ”-ний дагуу Улаанбаатар хотын “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын зардал нөхөх төлөвлөгөөг боловсруулах судалгааны ажлын хэсгийг Зохицуулах зөвөл, УСУГ, ОСНААУГ, болон хувийн хэвшлийн ОСНААБ-аас бүрдүүлж ажиллуулав.

5.23 ШУТИС-тай байгуулсан Хамтран ажиллах гэрээний дагуу орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарт ус хангамж, ариун цэврийн байгууламжийн ашиглалт, үйлчилгээний боловсон хүчнийг бүрдүүлэх, мэргэжлээрээ ажиллах нөхцөл бололцоогоор хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ШУТИС-ийн БАС-ын 2019-2020 оны хичээлийн жилийн төгсөгчидтэй /Усны барилга байгууламжийн ангийн 17, Ус хангамж, цэвэрлэгээний 13, Усны нөөц экологийн ангийн 11/ уулзалт зохиож, мэдээллээр хангав.



5.24 “Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь” сэдэвт зөвлөлдөх уулзалтын зөвлөмжийн хүрээнд 2020 оны холбогдох хэрэгжилтийн тайлангуудыг БХБЯ-д хүргүүлэв.

5.25 Нийслэлийн Захирагчийн ажлын албанд 2020.06.10-ны зохион байгуулсан ажлын хэсгийн хуралд оролцон “Буянт-Ухаа-1, 2” хорооллыг хариуцаж буй ТЗЭ байгууллага болон орон нутгийн өмчит байгууллагад ус хангамж, ариутгах татуургын шугам, сүлжээг хэрхэн хариуцуулах талаар санал өгөв.

5.26 Дэлхий нийтэд тархаад буй цар тахал Covid-19 вирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор “УСУГ” ОНӨААТҮГ-ын хариуцдаг тусгай зориулалтын автомашинаар бохир ус зөөвөрлөн нийлүүлэх 6 цэгийн үйл ажиллагааг сайжруулах, тусгай зөвшөөрөлгүй, “УСУГ” ОНӨААТҮГ-тай бохир ус нийлүүлэх гэрээ байгуулаагүй бохир ус зөөвөрлөж буй автомашиныудыг илрүүлэх, стандартын шаардлагад нийцээгүй бохир усыг дээрх цэгүүдэд нийлүүлж буй байдлыг шалган, бохир уснаас нь дээж авч шинжилгээ хийх, төвлөрсөн системд нийлүүлэгдэж буй бохир усны бохирдлын хэмжээг бууруулах, илэрсэн зөрчлийг



арилгуулахаар ЦЕГ-ын харъяа Экологийн цагдаагийн алба, “УСУГ” ОНӨААТҮГ-тай хамтарсан хяналт, шалгалтыг хийж, тайланг боловсруулан, холбогдох саналыг Нийслэлийн Байгаль орчны газарт хүргүүлэн ажилласан.

5.27 “УСУГ” ОНӨААТҮГ-ын хэрэглэгчидтэй байгуулах “цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах гэрээ”-ний төсөлд хэрэглэгчийн эрхтэй холбоотой асуудлаар холбогдох саналуудыг өгөв.

5.28 “Ус био инженеринг” ХХК-ийн төлөөлөгчидтэй уулзаж, төслөөр суурилагдаж байгаа цэвэрлэх байгууламжид тулгарч буй асуудлын талаар санал, солилцов.

5.29 “Баатардулаан хан” ХХК-иас “Астра вилла” хотхоны гүний худгийн усны чанарын шинжилгээ хийлгүүлэн, зөвлөмж авах хүсэлт ирүүлсний дагуу ШУА-ийн Газарзүй геоэкологийн хүрээлэнтэй хамтран дээрх ажлыг хийж гүйцэтгэн, зөвлөмж хүргүүлэв.



5.30 Сүхбаатар аймгийн “Дөрвөлж” ХХК-н хүсэлтийн дагуу ундны усыг цэвэршүүлэх, технологийн процесс болон оновчтой тоног төхөөрөмжийг сонгох шийдлийг Зохицуулах зөвлөлийн 2020.04.25-ны 01/403 тоотор хүргүүлэв.



5.31 Зохицуулах зөвлөлөөс НОБГ-тай хамтран байгууллагын галын аюулгүй байдлыг холбогдох дүрэм норм, стандартын дагуу хангах, урьдчилан сэргийлэх анхан шатны багаж хэрэгсэл, бодис материалыг бэлэн байлгах, нийт албан хаагчдад галын аюултай нөхцөл байдал үүссэн үед авах арга хэмжээний талаарх сургалтыг зохион байгуулав.

5.32 “Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын байгууллагуудад 01/524 тоот албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллав.

5.33 Монгол Улсын Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт /ҮАМАТ-08/-ыг шинэчлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ, “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНААТҮГ, “Монголын НААҮ-ний холбоо” ТББ болон “Монголын ОСНААҮ-ний ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо” ТББ-ны төлөөлөлтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав.



5.34 Зохицуулах зөвлөл нь Монголын Мянганы сорилтын сантай Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний өртгийг нөхөх зорилгоор “УСУГ-ын Зардал нөхөх төлөвлөгөө”-г боловсруулж, батлуулах “Хэрэгжүүлэгч байгууллагын гэрээ”-г байгуулав.

5.35 Барилга, хот байгуулалтын яам, Зохицуулах зөвлөл, НҮБ-ийн Хүүхдийн сан, КОЙКА хамтран “Цар тахлын үед ус хангамж, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний тогтвортой менежментийг хангах нь” сэдэвт зөвлөлдөх уулзалтыг 10 сарын 29-нд зохион байгуулсан. Үүнд Монгол улсын Шадар Сайдын Ажлын алба, БХБЯ, Сангийн яам, БОАЖЯ, ЭМЯ, БШУЯ, ХХААХҮЯ-д, төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн 60 орчим байгууллагын төлөөлөл оролцов.



5.36 Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын төлөөлөлтэй 10 сарын 01-нд Монгол банкны зээлийн мэдээллийн сан болон “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургыг шинээр барьж байгуулах, шинэчлэх болон түүний ашиглалт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д оруулж буй нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асуудлаар уулзалт хэлэлцүүлэг зохиов.







5.37 Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Б.Бат-Эрдэнэ болон холбогдох төлөөлөлтэй 10 сарын 07-нд орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын үйл ажиллагаа, тэдгээртэй холбоотой гомдол, маргааны талаар уулзалт зохион байгуулав.



5.38 Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын удирдах албан тушаал хашиж байсан ахмадуудыг 10 сарын 07-нд хүлээн авч, салбарын өнөөгийн байдал, цаашид анхаарч авч хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудын талаар тэдний санал, зөвлөмжийг сонслоо.



- 5.39 Зохицуулах зөвлөлөөс Монголын Мянганы сорилтын сантай хамтран “Ус хангамж, ариутгах татуургын зардал нөхөх, хөрөнгө болон усны эрэлтийн менежмент” сэдэвт сургалтыг 2020 оны 10-р сарын 30,31-ны өдрүүд болон 11-р сарын 04, 05, 06, 07-ны өдрүүдэд Сити Зочид буудалд зохион байгуулав.
- 5.40 Монголын НААҮ-ний холбоо” ТББ-аас зохион байгуулсан нягтлан бодогчдын сургалтаар 20 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөлд Бизнес төлөвлөгөө боловсруулах болон бусад дүрэм зааврын талаар заавар зөвлөгөө өгөв.
- 5.41 Хууль, эрх зүйн хөгжлийн хүрээлэнгийн гүйцэтгэсэн “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах БХБЯ-2018-РЗҮ-002 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээт ажлыг дүгнэв.





## ЗУРГАА. БУСАД

- 6.1 ТЗЭ байгууллагуудаас 2020 оны тайлан мэдээ авах маягыг шинэчлэн, байгууллагын сайтад байршуулан, мэдээлснээр УХАТ-ын үйлчилгээний мэдээлийн сангийн өгөгдлийг бүрдүүлэн ажиллав.
- 6.2 Монголын Мянганы сорилтын сангийн хүсэлтээр тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын 2018, 2019 оны засварын ажлын тайлангийн судалгааг гаргав.
- 6.3 БХБЯ болон Үндэсний хөгжлийн газраас зохион байгуулсан “Үндэсний



хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл оролцогч талуудын нэгдсэн хурал”-д оролцон, 21 аймгийн НАА-н байгууллагуудын танилцуулгыг бэлтгэн, аймгийн Засаг дарга нарт тухайн аймагт үйл ажиллагаа явуулж буй ТЗЭ-чдийн талаарх мэдээллийг хүргэв.

- 6.4 Сангийн яамны 4-3/2702 тоот албан бичгийн дагуу Орон сууц, нийтийн аж, ахуйн байгууллагуудад дэмжлэг хүсэх тухай санал боловсруулж 01/250 тоотоор 21 аймгийн Засаг дарга нарт хүргүүлэв.
- 6.5 Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоол батлагдсантай холбогдуулан Улаанбаатар хот, орон нутгийн ТЗЭ-чид болон аймгуудын 330 сумын хэрэглэгчдийн судалгааг авч, нэгтгэв.
- 6.6 “Ус сувгийн удирдах газарт хур борооны усны төлбөр тогтоох зөвлөх үйлчилгээ” -ний зөвлөхийн эцсийн тайланг боловсруулж “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-т хүргүүлэв.
- 6.7 Тусгай зөвшөөрөл эзэмшигч 130 аж ахуйн нэгж, байгууллагуудын 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг нэгтгэж, 01/430 тоотоор Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлэв.
- 6.8 Тусгай зөвшөөрөл эзэмшигч 151 байгууллагад “Эрүүл мэндийн яамны зөвлөмжийг байгууллагынхаа үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, нийт

ажилтан, албан хаагчиддаа заавар чиглэл өгч, Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг баримталж ажиллах тухай” 01/402 тоотыг хүргүүлэв.

- 6.9 Архивын Ерөнхий Газраас Зохицуулах зөвлөлийн архивын баримтын хадгалалт болон хамгаалалтын нөхцөл, баримтын бүрэн бүтэн байдал, ашиглалтын үйл ажиллагаанд албан хэрэг хөтлөлтийн талаар холбогдох мэргэжлийн зөвлөмж дүгнэлт авч, төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг тайлагнав.
- 6.10 Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын орон сууцны байрны байршлыг google earth програмд дүүрэг тус бүрээр оруулж, сан үүсгэв.
- 6.11 Хөрсний ус, бохирдлын асуудлаар зөвлөмж боловсруулж 02/557 тоотоор “Булнайн-Ар” ХХК-д хүргүүлэв.



- 6.12 Өвөрхангай аймагт Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын салбарын “Удирдах ажилтны зөвлөгөөн”-д оролцов.
- 6.13 Эрчим хүчний зохицуулах хорооноос аймаг, орон нутгийн дулааны тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын талаарх судалгааг гаргуулж, аймаг сумдын түвшинд нийтийн аж ахуйн үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангах ажлын хэсэгт орж ажиллав.








- 6.14 Архангай аймгийн Цэцэрлэг хот /Эрдэнэбулган сум/-д 2020.09.03, 04-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Цэвэрлэх байгууламжийн технологи, үйл ажиллагаа, эрсдэлийг бууруулах арга хэмжээний сургалт, цэвэр, бохир усны үнэ тарифын хэлэлцүүлэг”-т Бохир усны үнэ тарифын өртгийн талаар илтгэл тавив.
- 6.15 Сумын хөгжлийн стратеги хөтөлбөр төслийн эхний ажлын хэсэгт орж, тусгай зөвшөөрөлтэй 20 аж ахуйн нэгж, байгууллагын танилцуулгыг хийж, усны үйлчилгээний тарифын аргачлал, 2 дахь ажлын хэсэгт төслийн үр ашгийн шинжилгээг, 3 дахь ажлын хэсэгт төсөл хэрэгжүүлэх нэгж болон зөвлөх багийн төсвийн тооцоог гаргав.



- 6.16 АХБ-ны хөрөнгө оруулалтаар хийгдэж буй цэвэрлэх байгууламж барих төслийн үр ашгийн шинжилгээг хийв.
- 6.17 АХБ-тай хамтран Зохицуулах зөвлөлийн дэргэдэх Сургалт, судалгааны төвийг бэхжүүлж, нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын боловсон хүчнийг чадавхижуулах чиглэлээр ажиллах төслийн саналыг боловсруулав.
- 6.18 “Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилтны өдөр-2020” өдөрлөгийг 10 сарын 09-нд Сүхбаатарын талбайд зохион байгуулав.



- 6.19 “Төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх” төслийн хамтын ажиллагааны уулзалтад оролцов.



- 6.20 ХХААХҮЯ-тай хамтран Ховд аймгийн арьс ширний үйлдвэрийн урьдчилсан цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж ажиллан дүгнэлт зөвлөмж боловсруулж, тус яамны сайдад танилцуулав.
- 6.21 Ковид-19 цар тахлаас шалтгаалан Нийтийн аж ахуйн салбарын орлого, авлага, өр төлбөр, борлуулсан усны хэмжээ талаар судалгааг гаргав.
- 6.22 Улаанбаатар хотын “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын Урьдчилсан цэвэрлэх байгууламжд зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцов.
- 6.23 Салбарын 2019 оны үйл ажиллагаа, санхүү эдийн засгийн байдалд хийсэн хяналт үнэлгээний тайланг боловсруулав.
- 6.24 Тарифын санал, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зардлыг хянахад зориулан Жишиг зардлын хэмжээг шинэчилж, салбарын 2021 оны орлогын нэгдсэн төлөвлөгөөг хянав.
- 6.25 Нийтийн аж ахуйн салбарын Урт хугацаат зээлийн танилцуулгыг төсөл тус бүрээр гаргаж нэгтгэв.





# ДОЛОО

## ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл хувиар
Нийт орлогын дүн	1,323,827.30	1,482,752.20	110%
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,323,827.30	1,323,827.30	100%
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		138,475.10	
Нийт зарлагын дүн	1,323,827.30	1,443,706.40	109%
Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл	737,868.00	693,778.1	94%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,334.00	77,334.00	100%
Хангамж, бараа материалын зардал	38,147.80	28,898.50	75%
Эд хогшил худалдан авах	69,365.10	20,010.70	29%
Томилолт, зочны зардал	112,171.80	18,150.70	16%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	199,476.00	174,612.00	87%
Бараа үйлчилгээний бусад зардал	32,364.60	30,640.80	95%
Тоног төхөөрөмж		356,747.00	
Ажиллагсдын тоо	24	22	







ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

🏠 “Монгол Ньюс” тауэрын 6 давхар, 8-р хороо, Их тойруу 81/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс

☎ (+976) 7014-7447  
🌐 <http://www.wsrc.gov.mn/>  
✉ [info@wsrc.mn](mailto:info@wsrc.mn)